



**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ ХҮЛЭЭСЭН
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ХҮРЭЭНД АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилгоор дараах байгууллага, албан тушаалтнуудад ДААЛГАХ нь:

НЭГ. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газар, хэлтсийн дарга нарт:

- 1.1 Газрын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах;
- 1.2 Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах;
- 1.3 Хаягжуулалтын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж хэлэлцүүлэх;
- 1.4 Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах;
- 1.5 ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах;
- 1.6 Газрын төлбөр, татварын холбогдох журам, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, хэлэлцүүлэх;
- 1.7 Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн тохиолдолд дуудлага худалдаа, газар олгох, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх, асуудлыг Газар зохион байгуулалт хийх журамд нэмж тусгах;
- 1.8 Газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээ олгох журамд хилийн цэсийн зөрүүтэй нэгж талбарын зөрчлийг арилгах асуудлыг тухайн жилийн төлөвлөгөөнд тусгахгүйгээр зөрчил арилгах өргөдлийн төрлөөр шийдвэрлэх нэмж тусгах;
- 1.9 Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, 34 дүгээр зүйлийн 34.11, 40 дүгээр зүйлийн 40.1.4-т заасан газар эзэмших гэрээ байгуулахаас өмнө археологи, палентлогийн судалгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх зэрэг асуудлыг тодорхой болгох;
- 1.10 Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичгүүдийг уялдуулж нэгдсэн байдлаар нэгж талбар бүрээр цогцоор нь төлөвлөсөн газар ашиглалтын төлөвлөгөөтэй байх, түүнийг үндэслэж тухайн жилийн төлөвлөгөөнөөс үл хамаарч газар олгодог байх зохицуулалтыг тусгах;

1.11 Ашигт малтмалын ашиглалтын талбайг эзэмшүүлэх, ашиглуулах хууль эрх зүйн орчныг тодорхой болгох, зарим төрлийн газар ашиглалт, газрын эрхүүдийг тусгай зөвшөөрлийн талбайтай давхцаж орох боломжийг бүрдүүлэх;

1.12 Тариалангийн бүс нутаг дахь бэлчээр, тариалан, хадлангийн газрын төлбөрийн дээд доод хязгаарыг тогтоох эрхийг орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгох асуудлыг судалж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

1.13 Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль болон норм дүрмийн уялдааг сайжруулах, ялангуяа өмчлөлийн газрыг төлөвлөж, олгох асуудлыг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

1.14 Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээнд газар өмчлүүлэхдээ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн нийгмийн дэд бүтэц бий болсон газарт газар өмчлүүлэх бодлогыг баримталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

1.15 Газар дээрээ олон жил амьдарсан, үл хөдлөх хөрөнгөтэй иргэдийн газрыг гэрчилгээжүүлэх асуудлыг хууль эрх зүйн хүрээнд судалж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

1.16 Хөрөнгө оруулалтын хэлбэр өөрчлөгдсөн нөхцөлд газар эзэмших, ашиглах эрх хооронд шилждэг байх асуудлыг судалж танилцуулах;

1.17 Төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээнд хамаарах субъект, газрын зориулалтыг нарийвчлан Газрын тухай хуулийн төсөлд тусгах;

1.18 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа зориулалтыг өөрчлөхөд дуудлага худалдааны анхны үнэ төлөх эсэх зохицуулалтыг тодорхой болгох;

1.19 Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд мал бэлчээх, оторлох болон бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байхыг хориглоно” гэж заасныг бодит байдалтай уялдуулах;

1.20 Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14-т “Газрыг хамгаалах, нөхөн сэргээх, Газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих” гэж заасан ч хяналт тавих боломж хомс, газрыг хамгаалсан, нөхөн сэргээсэн талаарх мэдээлэл маш дутмаг байдаг. Эвдэрсэн болон нөхөн сэргээсэн газрын нэгдсэн мэдээллийн санг улсын хэмжээнд бий болгох ажлыг зохион байгуулах;

1.21 Засгийн газрын 2024 оны 173 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан үйлчилгээний хураамж болон тэмдэгтийн хураамжийг цахимаар төлүүлэх боломжийг бүрдүүлэх;

1.22 Газрын төлбөр, татварын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийж, газрын төлбөр тооцох, ногдуулалт, нэхэмжлэх үүсгэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх;

1.23 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн дэд системүүдийн уялдааг сайжруулах, www.ebarilga.ub.gov.mn гэх мэт бусад байгууллагын системүүдтэй холбох;

1.24 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг дундын мэдээллийн сангаар дамжуулан бусад байгууллагуудтай холбох, бодит цаг хугацааны мэдээллийг хүлээн авч ашиглах боломжийг бүрдүүлэх;

1.25 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын үл хөдлөх, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн мэдээллийн сантай холбож дундын мэдээллийн санг байгуулах;

1.26 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг Ашигт матмал газрын тосны газрын мэдээллийн сантай холбож дундын мэдээллийн санг байгуулах;

1.27 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг Татварын ерөнхий газрын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн санг байгуулан газрын эрх шилжүүлсний орлогын албан татварын үйлчилгээг цахимжуулах;

1.28 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах шатанд төлөвлөлтийн нэгж талбарын хэлбэр хэмжээг цахим системд өөрчлөх асуудлыг шийдвэрлэх;

1.29 Газрын харилцааны үйлчилгээг цахимжуулан иргэн, хуулийн этгээдийн хүсэлт гаргахад шаардагдах цаасан баримт, бичгийг цахимжуулах;

1.30 Иргэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар авахдаа төлөвлөлтийн нэгж талбараас өөрсдөө сонгодог байх нөхцөлийг бүрдүүлэх;

1.31 Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын даамлын ажлын байрны зураглал хийж ачааллыг тооцон, орон тоог нэмэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;

1.32 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлж, системийн ачааллыг шийдвэрлэх;

1.33 Ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг шинэчилж, сүлжээний хурдыг сайжруулан өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах.

ХОЁР. 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нарт:

2.1 Улсын Их Хурлын 2023 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хангах хүрээнд Малчдын хоршоонд тэжээлийн ургамал тариалах газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн тогтоож атар газрыг тариаланд шилжүүлэх саналыг боловсруулж сум, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралаар хэлэлцүүлж Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах;

2.2 Дараах газруудыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулж, тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй эрх зүйн харилцаа үүссэн болон үүсээгүй нэгж талбарууд, газар ашиглалтын дэлгэрэнгүй судалгааг гаргах, Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа зохион байгуулах, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж саналыг журамд заасан хугацаанд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах. Үүнд:

- Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Орхон, Сайхан суманд аж үйлдвэрийн парк байгуулах газар;
- Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт салаа төмөр зам барих газар;

- Хилийн боомт бүхий 14 аймагт “Шинэ сэргэлтийн бодлого” боомтын сэргэлтийн хүрээнд Боомтын бүс газар;

2.3 Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг холбогдох байгууллагуудтай хамтран тогтоож, батлуулах ажлыг зохион байгуулах;

2.4 Аймаг, нийслэлийн хэмжээнд хот суурины эдэлбэр газрыг тогтоох ажлыг зохион байгуулж, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

2.5 Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх, хилийн цэсийн маргаан болон бэлчээрийн газарт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, орон нутгийн онцлогт нийцүүлэн Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмыг боловсруулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулах;

2.6 Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинээр боловсруулах, тодотгох зардлыг газрын төлбөр, дуудлага худалдаа, малын тоо толгойн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөр зэрэг орлогоос шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;

2.7 Аймгийн төвийн сум болон бусад тэлэх шаардлага үүссэн сумдын хилийн цэсийг тэлэх саналыг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж аймгийн Засаг даргаар уламжлуулж ирүүлэх;

2.8 Хил залгаа аймаг сумд иргэн хуулийн этгээдийн харьяалал хамаарахгүй төлөвлөлтийн дагуу иргэдэд газрын эрх олгох асуудлыг шийдвэрлэх талаар хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах;

2.9 Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээнд газар өмчлүүлэхдээ хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн инженер, нийгмийн дэд бүтцэд холбогдсон байршилд төлөвлөх;

2.10 Хот суурин газар дээр жил бүр тогтмол хугацаанд дроны зураг авалт хийж газар ашиглалтын судалгааг хийж, түүнд үндэслэн газар зохион байгуулалтын төлөвлөлт хийх;

2.11 Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж байгаа аймаг, сумд төлөвлөгөө боловсруулах үе шат бүрд газар дээр нь хяналт тавьж, дүгнэлт гарган Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлэх;

2.12 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа аймаг, сумдууд гүйцэтгэгч компанид хяналт тавих төлөвлөгөөний бүс арга хэмжээгээ бүрэн оруулж байгаа эсэхэд хяналт тавих, шаардлага хангахгүй дутуу нөхцөлд хүлээж авахгүй байх, батлах хянах эрх бүхий байгууллагад энэ талаар албан ёсоор мэдэгдэж хамтран ажиллах;

2.13 Хот суурин газрын авто замын зурвас, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүсийн мэдээллийг тогтмол шинэчлэх асуудлыг шийдвэрлэх;

2.14 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, баримт материал, тайлантай танилцаж бүсчлэлд зөвшөөрөгдөх төрлүүдийг тодорхой болгох, газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулахад ерөнхий архитектурын оролцоог заавал хангах;

2.15 Шаардлага хангахгүй, бодит байдалд нийцэхгүй хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, шинэчлэх ажлыг зохион байгуулах, сумын нутаг

дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд хот суурины эдэлбэр газарт газар ашиглалтыг нэгж талбар бүрээр төлөвлөж хэрэгжүүлэх;

2.16 Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн төлөвлөлт, зохион байгуулалтын алдаатай (мухар гудамж, орц гарцын асуудал гэх мэт) байршлуудад төсөв батлуулан шинэчлэн зохион байгуулалт хийх;

2.17 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа гүйцэтгэгч компанид хяналт тавих, төлөвлөгөөний бүс арга хэмжээгээ бүрэн оруулж байгаа эсэхэд хяналт тавих, шаардлага хангахгүй дутуу нөхцөлд хүлээж авахгүй байх, батлах хянах эрх бүхий байгууллагад энэ талаар албан ёсоор мэдэгдэж хамтран ажиллах;

2.18 Хуулиар олгосон үйл ажиллагаа /газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, газар ашиглалтад хяналт тавих зэрэг/-г эрхлэхдээ орон зайн суурь мэдээллийг тогтмол ашиглах;

2.19 Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14.газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих; гэж заасны дагуу эвдэрсэн болон нөхөн сэргээсэн газрын мэдээллийг цахим системд бүртгэх;

2.20 Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5, 58.6 дахь хэсэг болон Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээр, тариалан, хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар болон улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хянан баталгааны ажлын зардлыг орон нутгийн төсөв, газрын нөөц ашигласны төлбөрийн орлогоос шийдвэрлүүлэн зохион байгуулж, анх удаа өмчлөл, эзэмшил, ашиглалтад газрыг олгохдоо хянан баталгааны дүгнэлт гаргах;

2.21 Дорнод, Говь-Алтай, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий, Архангай, Төв аймгийн 100 сум газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулж Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлигийг тус тус хэрэгжүүлэх;

2.22 Уламжлалт, түүхэн газар зүйн нэрийг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулж /Тухайлбал, Засаг Даргын тамгын газарт Газар зүйн нэрийн зураг байршуулах гэх мэт/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлигийг хэрэгжүүлэх;

2.23 Ховд, Увс, Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн 101 сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2026 оны орон нутгийн төсөвт батлуулан зохион байгуулж Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлигийг тус тус хэрэгжүүлэх;

2.24 Засгийн газрын хэрэгжүүлж буй мега төслүүд, аймгуудын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдтэй уялдуулан аймаг, сумын төвийн нутаг дэвсгэрийг 1:1000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлыг 2026 оны орон нутгийн төсөвт батлуулан зохион байгуулж Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх;

2.25 Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх, олон нийтийн санал авах; /2025 оны 2-3-р сар/

2.26 Аймгийн төв, сумын төв, томоохон суурин газрын төвийн нутаг дэвсгэрийг 1:1000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлыг 2026 оны орон нутгийн төсөвт батлуулан зохион байгуулж Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх;

2.27 Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталгаажуулах;

2.28 Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгааны ажлын үр дүнгээр илэрсэн газар ашиглалтын зөрчлийг арилгах, элэгдэл эвдрэл, бохирдол, доройтолд өртсөн газруудыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үе шаттайгаар тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.29 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын даалгаврыг боловсруулж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас санал авч батлуулах, мэргэжлийн байгууллагын гүйцэтгэлийн бүх үе шатанд хяналт тавьж, оролцоотой хамтран ажиллах;

2.30 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын эцсийн тайлан, үр дүнг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хянуулах, Газрын мэдээллийн цахим системийн мэдээллийн санд оруулж байгаа байдалд хяналт тавих;

2.31 Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааг Газрын тухай хуулийн 58.5-58.7 дах хэсэгт заасны дагуу зайлшгүй хийлгэх шаардлагатай нэгж талбарын судалгааг гаргаж, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарт мэдэгдэх хуудсыг хүргүүлж, захиалгат хянан баталгааны ажлыг зохион байгуулах, холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.32 Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг сум, орон нутгийн хэмжээнд холбогдох албан хаагч, удирдлагатай хамтран зохион байгуулах, ажлын үр дүнд үндэслэн бэлчээрийн газрыг хамгаалах, сайжруулах зөвлөмжийг Газрын тухай хуульд заасан “Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журам”-ын хүрээнд боловсруулж, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлэх;

2.33 Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын үр дүнг Газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлэх, хээрийн хэмжилт, судалгаанд ашигладаг багаж, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг сум, орон нутагтай хамтран хэрэгжүүлэх;

2.34 Иргэд, хуулийн этгээдэд өөрсдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, чанарыг байнга хянаж байх, газраа зөв зохистой ашиглах хамгаалах чиглэлээр тодорхой мэдлэг, ойлголттой болох, улмаар газар ашиглалтын зөрчил, газрын бохирдол, доройтолд өртөх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээг зохион байгуулж, энэ талаар боловсон хүчний чадавхыг сайжруулах;

2.35 Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэхэд шаардлагатай хэмжилтийн багажийн хэвийн ажиллагааг хангах, агаарын зураг авах нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/-ийг үйл ажиллагаандаа ашиглах;

2.36 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын орон зайн мэдээллийг MNS 6925 1-18:2021 багц стандартын дагуу бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

2.37 Орон зайн өгөгдөл мэдээллийг бүрдүүлэхдээ Засгийн газраас баталсан байрлал, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог чанд мөрдөх, мэдээллийн алдаагүй үнэн, зөв байдалд хяналт тавих;

2.38 Орон зайн өгөгдөл, мэдээлэл боловсруулахад шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамж /газар зүйн мэдээллийн системийг шинэчлэх, худалдан авах ажлыг зохион байгуулан ажиллах;

2.39 Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн орон зайн сэдэвчилсэн зурган мэдээллийг боловсруулж, тухай бүр нь ханган ажиллах;

2.40 Хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрдүүлсэн болон өөрчлөгдсөн орон зайн өгөгдөл, мэдээллийг тухай бүр Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системд нийлүүлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулах;

2.41 Байгууллагын албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй компьютеруудыг домайн удирдлагын сүлжээнд оруулах;

2.42 Байгууллагын албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй компьютерууд болон мэдээлэл дамжуулах сүлжээний тоног төхөөрөмжүүдэд хорт код /antivirus/ эсэргүүцэх программ хангамжийг бүрэн суулгах ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газартай хамтран зохион байгуулах;

2.43 Хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд мэдээлэл дамжуулах сүлжээний хэвийн ажиллагааг хангах;

2.44 Хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд аливаа шийдвэрт орон зайн өгөгдөл, мэдээллээр дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргагчдыг үнэ, зөв мэдээллээр хангах;

2.45 Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэгдээгүй төлөвлөлтийн баримт бичгүүдийн судалгааг гаргаж, цахим системд бүрэн оруулах ажлыг зохион байгуулах;

2.46 Иргэн, хуулийн этгээдэд газартай холбоотой үйлчилгээний шат дамжлагыг багасгах, цаасан материал шаардахгүй байх, цахимаар үйлчилгээг үзүүлэх;

2.47 Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүй шинээр газар олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байх;

2.48 Иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой 27 төрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байх;

2.49 Газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд цахимаар хүргэх ажлын хүрээнд киоски машиныг үйл ажиллагаанд нэвтрүүлж, тоог нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах;

2.50 Нэгж талбарын цаасан болон цахим хувийн хэргийн материалын бүрдлийг сайжруулах, хяналт тавьж ажиллах;

2.51 Барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар авах хүсэлт илгээхээс эхлээд эскиз загвар зураг, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргуулах зэрэг барилгын зөвшөөрлийн шат дараалсан үйл ажиллагаа цахимжуулснаас гадна инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх ажлын үйл ажиллагааг цахимжуулсан тул шийдвэрлэлтийн явцыг харах, хянах, батлах процессыг Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр хийх;

2.52 Хаягийн мэдээллийн системд бүртгэгдээгүй гудамж, зам, талбай, орц гарцын орон зайн өгөгдлүүдийг мэдээллийн санд бүртгэх.

ГУРАВ. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргад :

3.1 Улсын их хурлын 2023 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хангах хүрээнд Малчдын хоршоонд тэжээлийн ургамал тариалах газрыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн тогтоож атар газрыг тариаланд шилжүүлэх саналыг боловсруулж сум, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралаар хэлэлцүүлж тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.2 Дараах газруудыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулж, тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй эрх зүйн харилцаа үүссэн болон үүсээгүй нэгж талбарууд, газар ашиглалтын дэлгэрэнгүй судалгааг гаргах, Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа зохион байгуулах, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж саналыг журамд заасан хугацаанд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах. Үүнд:

- Нийслэлийн Багануур дүүрэгт аж үйлдвэрийн парк байгуулах газар;
- Нийслэлийн Багануур дүүрэгт салаа төмөр зам барих газар;

3.3 Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээнд газар өмчлүүлэхдээ хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн инженер, нийгмийн дэд бүтцэд холбогдсон байршилд төлөвлөх;

3.4 Хот суурин газар дээр жил бүр тогтмол хугацаанд дроны зураг авалт хийж газар ашиглалтын судалгааг хийж, түүнд үндэслэн газар зохион байгуулалтын төлөвлөлт хийх;

3.5 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа гүйцэтгэгч компанид хяналт тавих төлөвлөгөөний бүс, арга хэмжээгээ бүрэн оруулж байгаа эсэхэд хяналт тавих, шаардлага хангахгүй дутуу нөхцөлд хүлээж авахгүй байх, батлах хянах эрх бүхий байгууллагад энэ талаар албан ёсоор мэдэгдэж хамтран ажиллах;

3.6 Нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран тогтоох ажлыг зохион байгуулах, батлуулах, дэглэмийг мөрдүүлэх;

3.7 Хот суурин газрын авто замын зурвас, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүсийн мэдээллийг тогтмол шинэчлэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

3.8 Нийслэлийн хэмжээнд хот суурины эдэлбэр газрыг тогтоож тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

3.9 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, баримт материал, тайлантай танилцаж бүсчлэлд зөвшөөрөгдөх төрлүүдийг тодорхой болгох, газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулахад ерөнхий архитекторын оролцоог заавал хангах;

3.10 Баянгол, Налайх дүүргийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2026 оны орон нутгийн төсөвт батлуулан зохион байгуулж Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлигийг тус тус хэрэгжүүлэх;

3.11 Нийслэлийн нутаг дэвсгэрийн төлөвлөлт, зохион байгуулалтын алдаатай (мухар гудамж, орц гарцын асуудал гэх мэт) байршлуудад төсөв батлуулан шинэчлэн зохион байгуулалт хийх;

3.12 Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулах;

3.13 “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” нээлттэй хаалганы өдөрлөг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулах;

3.14 Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системийн хөгжүүлэлтийг хамтарч гүйцэтгэх;

3.15 Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулах;

3.16 Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14.газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих; гэж заасны дагуу эвдэрсэн болон нөхөн сэргээсэн газрын мэдээллийг цахим системд бүртгэх;

3.17 Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэгдээгүй төлөвлөлтийн баримт бичгүүдийн судалгааг гаргаж, цахим системд бүрэн оруулах ажлыг зохион байгуулах;

3.18 Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүй газар олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байх;

3.19 Иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой 27 төрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байх;

3.20 Иргэн, хуулийн этгээдэд газартай холбоотой үйлчилгээний шат дамжлагыг багасгах, цаасан материал шаардахгүй байх, цахимаар үйлчилгээг үзүүлэх;

3.21 Газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд цахимаар хүргэх ажлын хүрээнд киоски машины тоог нэмэгдүүлэх;

3.22 Хаягийн мэдээллийн системд бүртгэгдээгүй гудамж, зам, талбай, орц гарцын орон зайн өгөгдлүүдийг мэдээллийн санд бүртгэх;

ДӨРӨВ. Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ТАВ. Энэхүү албан даалгаврыг холбогдох байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж, хагас, бүтэн жилээр биелэлтийг танилцуулж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ